

# БУЛГАН-УНДРАГА ХК

## “БУЛГАН УНДАРГА” ХК-Н ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 8 дугаар сарын 2-ны өдөр

№21/06

Улаанбаатар хот

### КОМПАНИЙН ОНООСОН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Булган Ундарга” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 5-р зүйлийн 5.5 дахь заалт, 2021 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн №02 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн оноосон нэрийг дараах байдлаар өөрчилсүгэй.

**Бүтэн нэр:** “Крипто Үндэстэн” ХК

**Англиар:** “Crypto Nation” Joint Stock Company

2. Компанийн оноосон нэрд орох өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монгол Хөрөнгийн Биржэд тус тус бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал албан тушаалтай Г.Мягмаржав-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

# БУЛГАН-УНДРАГА ХК

## “БУЛГАН УНДАРГА” ХК-Н ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 8 дугаар сарын 2-ны өдөр

№21/07

Улаанбаатар хот

### КОМПАНИЙН ЗАРЛАСАН ХУВЬЦААНЫ ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалт “Булган Ундарга” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 5-р зүйлийн 5.5 дахь заалт, 2021 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн №02 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн нийт зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлж, нэг бүр нь 100 /нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,000,000 /нэг сая/ ширхэг энгийн хувьцаатай байхаар тогтоосугай.
2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоонд өөрчлөлт оруулсантай холбоотой уг зарласан хувьцааны тоонд багтаан Компанийн гаргах хувьцааны тоо, гаргах хэлбэр, нөхцөлийг тогтоох бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
3. Компанийн зарласан хувьцааны тоонд оруулах өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал албан тушаалтай Г.Мягмаржав-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

# БУЛГАН-УНДРАГА ХК

## "БУЛГАН УНДАРГА" ХК-Н ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 8 дугаар сарын 2-ны өдөр

№21/08

Улаанбаатар хот

### КОМПАНИЙН НЭМЖ ГАРГАХ ХУВЬЦААНААС ТЭРГҮҮН ЭЭЛЖИД ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.8 дахь заалт, "Булган Ундарга" ХК ("Компани" гэх)-ийн Дүрмийн 5-р зүйлийн 5.5 дахь заалт, 2021 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн №02 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаниас нэмж хувьцаа гаргахтай холбоотой Компанийн хувьцаа эзэмшигчид нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр нэмж гаргах энгийн хувьцаанаас өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлсэн тоо хэмжээгээр тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг тогтоох бүрэн эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

# БУЛГАН-УНДРАГА ХК

## “БУЛГАН УНДАРГА” ХК-Н ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 8 дугаар сарын 2-ны өдөр

№21/09

Улаанбаатар хот

### КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Булган Ундарга” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 5-р зүйлийн 5.5 дахь заалт, 2021 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн №02 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралтаар баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг Хуулийн Этгээдийн Улсын Бүртгэлийн Газарт холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал албан тушаалтай Г.Мягмаржав-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ